

ТА ӨӨРИЙН МӨН ЧАНАРЫГ ҮНЭНЭЭР НЬ МЭДДЭГ ҮҮ?

ХОЁРДУГААР ДЭВТЭР:
*ХРИСТ ДОТОР ӨӨРЧЛӨГДСӨН АМЬДРАЛААР
АМЬДРАХУЙ*

БИЛЛ ЛОВЛЕСС
ХРИСТ БОЛ АМЬДРАЛ ҮЙЛЧЛЭЛ

ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН МЭДЭЭЛЭЛ

Copyright © 2010 by Bill Loveless

All rights reserved. This book may not be copied or reprinted for a commercial gain or profit. The use of this material for personal or group study is permitted.

Scripture taken from the Holy Bible, New International Version®, copyright © 1973, 1978, 1984 International Bible Society. Used by permission of Zondervan. All rights reserved.

Scripture taken from the Holy Bible, New Living Translation, copyright © 1996 by Tyndale Charitable Trust. Used by permission of Tyndale House Publishers.

Scripture taken from the New American Standard Bible®, copyright © 1960, 1962, 1963, 1968, 1971, 1972, 1973, 1975, 1977, 1995 by The Lockman Foundation. Used by permission.

Scripture taken from the New King James Version, copyright © 1982 by Thomas Nelson, Inc. Used by permission. All rights reserved.

Scripture quotations marked (GNT) are from the Good News Translation in Today's English Version—Second Edition, copyright ©1992 by American Bible Society. Used by permission.



Christ Is Life Ministries

Website: www.christislifeministries.com

Email: bill@christislifeministries.com

НОМЫГ СУДЛАХ АРГАЧЛАЛ

“Та Өөрийн Мөн Чанарыг Үнэнээр нь Мэддэг үү?” гэсэн энэхүү номыг судлахаар сонгосонд талархал илэрхийлье. Таныг эхлэхээс өмнө энэхүү номыг хэрхэн судлах талаар багахан тайлбар хийе. Энэхүү номонд зургаан хичээл байгаа бөгөөд хичээл тус бүр 5 дэд хичээл буюу 5 өдөр уншиж судлах материалтай (Өдөр 1, Өдөр 2...) болно. Та өөрийн баг хамт олонтой долоо хоног тутам нэг уулзалт хичээл хийхээр төлөвлөж байгаа бол 5 өдрийн унших материалтай танилцан хийж гүйцэтгэхэд танд долоон өдөр өгөгдсөн байна гэсэн үг юм. Хичээл тус бүрт холбогдох **асуултууд, чимээгүй цаг гарган бодох ишлэлүүд, мөн Бурхантай ярилцах нь** гэсэн хэсгүүд байгаа.

Асуултууд:

Асуултууд нь та тухайн өдрийн хичээлийн дагуу мэдэж авсан үнэнг өөрийн өмнө нь итгэж байсантай харьцуулан бодоход зориулагдсан болно. Та ямар нэгэн худал хуурмагт итгэж байгаа бол энэхүү асуултууд нь тэдгээрийг илчлэн харуулах зорилготой юм.

Чимээгүй цаг гарган тунгаан бодох ишлэлүүд:

Бясалгах гэдэг үгийн бусад шашинд хэрэглэгддэг утгаас болоод зарим хүмүүс хэрэглэхдээ эргэлздэг. Гэвч энэ нь библийн дагуух үг тул хэрэглэхээс зайлсхийх хэрэггүй бөгөөд гол түлхүүр нь **ЮУГ** болон **ХЭНИЙ ТУХАЙ** бясалгаж байна вэ гэдэгт л байгаа юм. Бидний бясалгалын утга учир нь Бурхан болон Бурханы үнэн дээр байх ёстой. Энэ номын хүрээнд бясалгах гэдэг үг нь уншин судалж буй үнэнийхээ талаар тунгаан бодох гэсэн утгаар ашиглаж байгаа болно.

Бурхантай харилцах цаг гаргах нь:

Энэ библи судлалын хамгийн чухал хэсэг нь хичээл болгоны Бурхантай харилцах нь гэсэн хэсгүүд юм. Энэ хэсэгт та уншиж судалсан зүйлийнхээ төлөө ойлголт, илчлэлт, хэрхэн амьдралдаа хэрэгжүүлж болохоо Ариун Сүнснээс асуухад зориулагдсан цаг юм. Таны эндээс шинээр суралцаж буй зүйлс урьд нь таны итгэж явсан ойлголтуудтай зөрчилдөж эхлэхэд Ариун Сүнсний туслалцаа маш чухал (Энэ л үедээ та Бурханы үнэнийг эрж хайхгүй бол та өөрийн итгэж буй зарим нэг худал хуурмаг ойлголтуудыг ялган салгаж таних боломжгүй байдаг) Тиймээс энэ цагийг онцгойлон гаргаж Бурхантай ярилцаарай.

Илчлэлт:

Энэ номд илчлэлт гэсэн үг олон удаа давтагдан гарах учир би энд энэхүү үгийг ямар утгатайгаар ашиглаж буйгаа тайлбарлая. Илчлэлт гэдэг нь Бурхан Өөрийн үнэнийг **ер бусын** аргаар миний амьдралын нөхцөлд тааруулан надад хувьчлан ойлгуулахыг хэлнэ. Илчлэлт таны ухамсар дахь ойлголтыг Бурханы үнэн болох сүнслэг ойлголт уруу шилжүүлж өгдөг.

ТҮЛХҮҮР ҮНЭН

Та энэхүү судлалын туршид дараах суурь үнэнг санаарай.

Та өөрийн итгэж байгаагаас илүү гарч амьдарч чадахгүй. Хэрэв таны итгэж байгаа зүйл худал хуурмаг бол таны амьдрал мөн тийм л байна.

Энэ яагаад чухал вэ гэвэл таны юунд итгэж байгаа тань таны бодол, зан үйл, болон хийх сонголтуудад шууд нөлөөлдөг юм. Тиймээс энэхүү библи судлалын нэг зорилго нь таны худал хуурмаг итгэсэн зүйлүүдийг танд илчлэн харуулах, өөрийн оюун бодлыг шинэчлэх, болон Иохан 8:32 ишлэлийн дагуу чөлөөлүүлэх юм. Энэхүү судлалыг хийж буй таны төлөө “худал хуурмаг үнэмшлээс мөн худал хуурмаг итгэлээс үүдэн гарч буй нөлөөллөөс таныг чөлөөлөх Бурханыг хайгаасай” гэж би залбирах болно.

ӨӨРИЙН ҮНЭН МӨН ЧАНАРЫГ УХАМСАРЛАСАН НЬ МИНИЙ АМЬДРАЛЫГ ХЭРХЭН ӨӨРЧИЛЖ БАЙНА ВЭ?

Христ доторх шинэ мөн чанарын талаарх үнэнийг зааж эхлэх болсон маань миний хувийн туршлагаас үүдэлтэй юм. Хэрэв би та бүхэнд хуваалцах гэж буй үнэнийг мэдэж, итгээгүй байсан бол миний амьдрал одоо бүхэлдээ зовлонтой байх байлаа. Би ууртай, захирангуй, догшин аавын гар дор өссөн. Харин миний ээж өөрийгөө ааваас хамгаалах байнгын бэлэн байдалд байдаг байв. Миний бага насны хүсэл бол ямар ч үнээр хамаагүй эцэг, эхдээ хайрлагдаж, хүлээн зөвшөөрөгдөх зүйлийг л хийх байдаг байлаа. Гэвч асуудал нь эцэг, эхийнхээ хайр, хүлээн зөвшөөрөл, үнэ цэнийг “хүртэх”-ийн тулд хийдэг зүйлс маань хэзээд хангалтгүй байдаг байсан юм.

Манай аавын уур уцаар, догшин авир нь би хайрлагдаж, хүлээн зөвшөөрөгдөхийн тулд би юу ч хийсэн хангалттай биш гэдэгт намайг үнэмшихэд хүргэжээ. Үүний үр дагаварт би өөрийнхөө талаар үнэмшлийг бий болгож эхэлсэн юм. Зарим нэгээс нь хуваалцвал:

- Би ямагт гологдмол байдлыг мэдэрдэг байсан тул би хүлээн зөвшөөрөгддөггүй.
- Би эцэг, эхийнхээ хайрыг татах хангалттай зүйлсийг хийдэггүй болохоор би хайрлагдах зохистой биш.

Миний аав намайг ийм байдалд оруулдаг байсан тул би өөрийгөө хангалтгүй гэж үнэмшсэн байлаа. 18 нас хүрэх үед эдгээр үнэмшлүүд маань илүү бэхжсээр миний амьдралын хүлээс болсон байв. Ахлах сургуулийн төгсөх ангийн сурагч байхдаа би Христийг Аврагч хэмээн хүлээн авсан боловч аврагдах үед маань хүмүүс надад маш чухал үнэнийг хэлэлгүй орхигдуулсан байжээ. Тэр орхигдуулсан үнэн бол Христ дотор би ШИНЭ бүтээл бөгөөд энэ нь намайг ШИНЭ МӨН ЧАНАРТАЙ болгодог!

Үүнээс хойш 30 жилийн турш би өөрийн хүчин чармайлтаар Христитгэлийн амьдралаар амьдрах гэж хичээсний эцэст өнөөх гологдмол, үнэ цэнэгүй, хангалтгүй байдлууд маань бүр ч дордсон. 1998 оны 10 сард сонссон 2 үнэн амьдралд маань огцом эргэлт авчрах хүртэл энэ нь үргэлжилсэн юм. Эхний үнэн



Өнөөдөр маш олон Христитгэгчид яг ийм амьдралаар амьдарч байгааг харахдаа би номынхоо нүүрэнд баг зүүсэн хүмүүсийг тавьсан билээ. Үүнийг мэдэж байгаа шалтгаан маань би өөрөө Христитгэлт амьдралаар амьдрахдаа олон төрлийн баг зүүж байсан учраас юм. “Баг” гэдгээр би юуг илэрхийлж байна вэ? Би гэрчлэлдээ дурдсанчлан надад өөрийнхөө талаар хангалтгүй, үнэ цэнэгүй, бүтэлгүй гэх мэт олон худал хуурмаг хувийн итгэл үнэмшлүүд байсан билээ. Энэ бүхэн Христ доторх мөн чанараа үнэнээр нь мэддэггүй байсантай минь холбоотой. Мөн би өөрийгөө хэрхэн хардагчлан бусдад харагдахыг хүсдэггүй байсан тул бусдад харуулах “шинэ би”-г бүтээсэн гэж болно. Ингэхдээ би өөрийн чадалд итгэсэн, бие даасан, амжилттайгаар харуулах багийг өмссөн юм. “Шинэ би”-д байсан асуудал нь өөрийнхөө талаар итгэж үнэмшсэн худал хуурмагаас үүдэлтэй шинэ боловч “хуурамч би” дотор байсан юм. Өөрөөр хэлбэл, би өөрийнхөө хуурмаг байдлыг өөр нэг хуурмаг байдлаар халхалсан гэсэн үг. Та харин яаж байна вэ? Танд өөрийнхөө талаар бий болгосон худал хуурмаг үнэмшлүүд байх

боломжтой юу? Мөн өөрийнхөө мэдэрдэг зүйлийг бусдад харуулахгүйн тулд ямар нэгэн баг/багуудзүүж байх боломжтой юу? Энэ нь бид өөрийн үнэн мөн чанарыг мэдэхгүй байгаагаас үүдэн гардаг үр дагавар гэж би боддог.



--

--

Би өөрийнхөө талаар гэж мэдэрч, итгэдэг

Өөрийгөө голдоггүй
Өөртөө итгэлтэй
Өөртөө сэтгэл хангалуун
Өөртөө амжилттай
Өөртөө найдсан
Өөрийгөө хянадаг
Өөрийгөө дайчилдаг
Өөрөө чадварлаг
Өөртөө эргэлздэггүй
Өөрөөрөө хүчирхэг

Дараах диаграмаар үүнийг илэрхийлье.



--

--

**Худал хуурмаг өөртөө итгэх итгэл үнэмшилээр амьдрах нь МАХАН БИЕЙН АВИРЫГ
бий болгодог**

--

Сөрөг махан биеийг танихад маш амархан байдаг нь тэрээр ерөнхийдөө сөрөг махан биеийн хандлага, ааш авирыг бий болгодог юм. Үүгээр ямар утгыг илэрхийлж байгааг тодорхой харуулах дараагийн жишээг харна уу.



Сөрөг махан биеийн жишээ: уур бухимдал, хангалтгүй байдал, үл уучлал, атаа жөтөө, хянах оролдлого, айдас, санаа зоволт.

Эерэг махан бие сэтгэл татам харагддаг тул олж илрүүлэхэд маш ярвигтай байдаг. Эерэг махан бие хэдийгээр сайхан харагддаг ч өөр дээрээ төвтэй эсвэл Бурханаас салангид бие даасан байдал дотор явагддаг зүйл юм. Эдгээр хоёр төрлийн жишээг харуулья.



1. ӨӨР ДЭЭРЭЭ төвлөрдөг эерэг махан биеийн жишээ: Өөртөө итгэлтэй, өөртөө түшиглэдэг, өөрийгөө болгосон, амжилттай, өөртөө зөвт



	Стресс	Айдас Гологдмол	Санаа зоволт Найдвар тасарсан Үл уучлал Бухимдал	Хувиа хичээсэн байдал Урам хугарал Сэтгэл ханамжгүй байдал
Үнэ цэнэгүйдэл	Бардамнал	Хорсол		

Санамж: Та худал хуурмаг өөртөө итгэх итгэл үнэмшлээ хаялгүй амьдарсаар байвал 2 Петр 2:22 ишлэл дээр Паулын илэрхийлж буйг мэдрэнэ гэсэн үг юм..



*“Тэдний хувьд **"Нохой бөөлжсөө долоодог, гахайг угаасны дараа шаварт буцаж хөлбөрдөг"** хэмээх сургаалт үгийн дагуу тохиолдсон аж.”*

Нохой бөөлжсөө долоодог, гахайг угаасны дараа шаварт буцаж хөлбөрдөг гэдэг бол худал хуурмаг өөртөө итгэх итгэл үнэмшлээ тавилгүй зууралдан амьдрахын тод зураглал юм. Ийм байсаар байтал бид яагаад байнга махан бие рүүгээ эргэж буцсаар байдаг вэ? Энэ бол бидний хэт дадсан байдал юм. Тэнэг мэт сонсогдож байгаа ч бид өөрийн тохилог байдалдаа тухлан, гэрийнхээ мухарт махан биеийн эмгэгтэйгээ л зууралдахад илүү дадсан байдаг гэсэн үг.

--

Асуулт: Ром 7:15-д тулгуурлан та хийхийг хүсдэг боловч хийхгүй байгаа зүйлүүд тань юу болох талаар дурдана уу? Та тэдгээр зүйлсийг өөрийнхөө сэтгэлийн тэнхээний хүчээр болих гэж хичээж байсан уу? Энэ нь хир үр дүнтэй байв?

--



Та эцэг эхийнхээ хүчирхийлэл (аман, сэтгэл зүйн, бэлгийн, бие махбодийн гэх мэт) дор өссөн бол та үнэ цэнэгүй эсвэл “бусдаас дорд” гэсэн итгэл үнэмшлийг өөртөө тээсэн байх боломжтой. Та үнэн дотор алхахад өөрийгөө дасгалжуулаагүй бол худал хуурмаг хувийн итгэл үнэмшил тань өөрийгөө хүчирхийлэгч нэгэн болгох эсвэл хүчирхийлэгч хүнтэй учруулах боломж тун өндөр. Нөгөө талаар тэдгээр нь таныг үнэн мөн чанараа олсон байдлаас ирэх эрх чөлөөг мэдрэхээс зайлсхийлгэх ч боломжтой.

Хэрэв та худал хуурмаг итгэл үнэмшилтэй ба үүнээс үүдэлтэй махан биеийн ааш авирыг гаргадаг эцэг эх бол энэ нь таны хүүхдүүдэд сөрөг нөлөө үзүүлэх болно. Жишээлбэл, таны уцаарлангуй ааш авир

таны хүүхдүүдийн үнэ цэнийг мохоож, үүний улмаас тэд эргүүлэн уур уцаартай хариу үйлдэл хийхэд хүрэх болно.

Төгс болохыг хичээх


Талархалгүй

Буруу, муу зүйлийг үгүйсгэх

Тэгж байгаад болно гэж
бодох

Санал бодол, мэдрэмжээ
хуваалцахад хүндрэлтэй
Сэтгэл хөдлөлөө нуух
Явцуу, зожиг

Баяр хөөргүй




ХУДАЛ ХУУРМАГ ИТГЭЛ ҮНЭМШИЛ

БИ:


ГЭЖ ИТГЭЖ, МЭДЭРДЭГ

A large, thick, black arrow pointing downwards from the bottom center of the circular form.







ГЭМИЙН УНАЛТААС ӨМНӨХ АДАМ, ЕВАГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ



АДАМ, ЕВА ГЭМ ҮЙЛДСЭНЭЭР ТЭД СҮНСЭЭР ҮХЭЖ, ЭХ СУРВАЛЖ, АМЬ
БОЛСОН БУРХАНААС ХАГАЦСАН.



Та төрөхдөө Адам, Евагийн сүнслэг нөхцөл байдлыг ӨВЛӨЖ АВСАН



ГЭМ АМЬДРАЛ




Христ бидний гэмийн
төлөө үхсэн Ефес 1:7

Бурханы ТӨГС ДҮҮРНИЙГ бүхлээр нь хүнд эргүүлэн авч иржээ.
Колоссай 2:9,10

Бурхан Өөрийн АМЬ & ХҮЧ ЧАДЛЫГ хүний дотор тавьжээ. Кол 3:4,
Ефес 1:19,20


Бурхан таны хуучин хүн, мөн чанарыг ЦОВДОЛЖ, шинэ сүнс, шинэ
мөн чанараар СОЛИЛЦОО хийсэн. Ром 6:6, 2 Коринт 5:17

Бурхан өөрийгөө тантай НЭГДМЭЛ болгосон. Иохан 14:20





ГЭМ

Христ таны гэмийн ТӨЛӨӨ үхсэн



Бурхан Өөрийн ТӨГС ДҮҮРНИЙГ бүхлээр нь хүнд эргүүлэн авч иржээ







--

--

Христ таны гэмийн ТӨЛӨӨ үхсэн




Дасгал:20-р хуудсаны диаграмд бичсэн зүйлсээ сөхөж хараад дараах диаграмын “хуучин мөн чанар” гэсэн хэсгийн доорх хоосон шугаманд өөрийн худал хуурмаг итгэл үнэмшлүүдээсээ бичнэ үү.




Хэрэв таны хуучин мөн чанарын нэг хэсэг болох худал хуурмаг итгэл үнэмшлүүд загалмайд ЦОВДЛОГДСОН юм бол та цаашид энэхүү худал хуурмагт итгэсээр байх ХЭРЭГ байна уу?

**Бурхан таны хуучин хүн болон хуучин мөн чанарыг шинэчлэгдсэн
сүнс болон шинэ мөн чанараар СОЛИЛЦОО
хийсэн**



**Бурхан таны шинэчлэгдсэн сүнстэй өөрийгөө НЭГДМЭЛ
болгожээ.**





Христ бидний гэмийн
төлөө үхсэн Ефес 1:7

Бурханы ТӨГС ДҮҮРНИЙГ бүхлээр нь хүнд эргүүлэн авч иржээ.
Колоссай 2:9,10

Бурхан Өөрийн АМЬ баХҮЧ ЧАДЛЫГ хүний дотор тавьжээ. Кол 3:4,
Ефес 1:19,20

Бурхан таны хуучин хүн, мөн чанарыг ЦОВДОЛЖ, шинэ сүнс, шинэ мөн
чанараар СОЛИЛЦОО хийсэн. Ром 6:6, 2 Коринт 5:17

Бурхан өөрийгөө тантай НЭГДМЭЛ болгосон. Иохан 14:20

ГУРАВДУГААР ХИЧЭЭЛ


Бүх хүн төрөлхтөн “АДАМ ДОТОР” төрсөн

АДАМ ДОТОР
(Бүх хүн төрөлхтөн)

Авралаас өмнө

Та Адамын :

- Сүнслэг үхэл
- Бурханаас салгагдсан байдал
- Буруутгагдсан байдал
- Хуучин мөн чанартай адилтгагдаж байсан



--


--

--

--

--

Таны сүнсэн дотор буй үнэн мөн чанар



Христ ДОТОР таны шинэ мөн чанарын гаргадаг шинжүүд





байх боломжтой. Христ дотор та бол хүлээн зөвшөөрөгдсөн нэгэн гэдэгт итгэх нь бусдыг болзолгүй хүлээн зөвшөөрөх эрх чөлөөг өгдөг.

Ариун Бурхан биднийг бүрэн хүлээн зөвшөөрсөн шалтгаан нь Тэр Өөрөө биднийг хүлээн зөвшөөрөхүйц болгосонд байгаа юм. Та магадгүй бусдаар гологдсон байдлыг мэдэрч байж болох ч энэ нь Бурхан таныг болзолгүйгээр хүлээн зөвшөөрдөг үнэнийг өөрчлөхгүй! Энэ нь Бурхан таныг хайрлахгүй байхад хүргэх тийм агуу гэмт зан чанар гэж байхгүй гэсэн үг юм. (Бурхан гэмт зан чанартай эвлэрдэггүй, гэхдээ Бурхан гэмт зан чанартай гээд таныг голдог биш) Тиймээс та Бурханы болон бусдын хүлээн зөвшөөрлийг олж авах гэж хичээх хэрэггүй болсон. Та Бурханы хүлээн зөвшөөрлийг хүлээн авч бусдад гологдохоос чөлөөтэй

ДӨРӨВ ДЭХ ӨДӨР



Та магадгүй өөрийгөө бүтэлгүй амьтан гэж хардаг байж болох ч Христ дотор та бол ялагч бөгөөд давуулан дийлэгч. Танаар дамжуулан ялах боломжгүй ямар ч асуудал, зөрчил, гамшиг Христэд байхгүй. Нөгөө талаар, та өөрийгөө Христээс ангид “өөрийгөө болгочихдог” ялагч, давуулан дийлэгч хэмээн харж байж болох юм. Христээс ангид бид **юуг ч** хийж чадахгүй нь нэгэнт үнэн учир (Иохан 15:5) Бурхан таныг хайрласандаа яах ч боломжгүй асуудлыг (харилцаа) таны амьдралд өгч та өөрийн хүч чадлаар давж гарч чадахгүйг илчлэн харуулахыг зорьдог. Өөрийн сул дорой, чадваргүй байдлыг ухамсарлах нь Бурханаас хамааралтай байдал руу биднийг хөтөлж танаар дамжуулан Тэр ялах боломжийг олгодог. Тиймээс өөрийн шинэ мөн чанар дотор Христийн ялалтаас эхтэй амьдарч эхлээрэй.



Та магадгүй хэн нэгнээр доромжлогдсон мэт санагдаж тэднийг уучлах тэнхээ байхгүй байж болох юм (магадгүй танд уучлахгүй байх эрх байгаа мэт санагдаж байж болох). Гэвч үнэндээ танд уучлахгүй байх шалтаг огтхон ч байхгүй. Яагаад? Учир нь та бол өөрийн үнэн мөн чанар дотор уучлангуй хүн юм. Та уучлахыг хүсч байгаа эсэхэд асуудал нь байгаа юм биш. Харин та Христ доторх үнэн мөн чанарынхаа улмаас уучлахыг сонгож чадна. Хэрэв та уучлах хүсэлгүй байвал, Бурханаас уучлах хүсэлтэй зүрхийг өгөхийг гуйгаарай.

Хэдийгээр таны хандлага, зан чанар Бурханы хэлж буй үнэнтэй давхцахгүй байлаа гээд Христ доторх таны мөн чанарын талаарх үнэн өөрчлөгдөх үү? Хариулт нь ҮГҮЙ! Христитгэгчийн хувьд, Бурхан

таны гэмт зан чанараас ангид, тусдаа шинэ мөн чанарыг таны сүнсэнд өгсөн. Авралаас өмнө таны хэрхэн авирлаж байгаа тань таны мөн чанарыг харуулдаг байсан.



--

--



Энэ асуулт бол маш чухал асуулт юм. Учир нь энэ асуулт хүний сүнс болон сэтгэл санааг яагаад ялгаж авч үзэх хэрэгтэйг гүнзгий илчилдэг юм. Хоёрдугаар хичээл дээр үзсэн зүйлээ санаж байгаа бол Бурхан таны хуучин үхмэл сүнс болон хуучин мөн чанарыг авч шинэ мөн чанартай шинэчлэгдсэн сүнсээр сольсон гэж гардаг. Асуудал нь юундаа байна вэ гэхээр шинэ мөн чанартай шинэчлэгдсэн сүнстэй болсон ч таны сэтгэл санаа худал хуурмаг итгэлээр амьдралаас эргэж шинэ мөн чанарын шинж чанаруудаар амьдрах тэр цэгт хүрэх хэрэгтэй болдог гэсэн үг. Үүнийг тайлбарлая.

Өөрчлөн шинэчлэлтээс өмнөх таны СЭТГЭЛ САНААНЫ нөхцөл байдал



Та энэ тайлбартай санал нийлэх үү? – Та өөрийнхөө талаар юу гэж боддог чинь өөрийн чинь талаарх итгэл үнэмшил юм. Жишээлбэл, та өөрийгөө итгэлгүй, дутуу дулимаг гэж боддог бол та өөрийгөө яг тийм гэж л итгэдэг? Өөрөөр хэлбэл, бодол, итгэл үнэмшил хоёр салшгүй холбоотой. Нэгэнт л таны бодол, итгэл хоёр оюун санаанаас тань урган гардаг тул Бурхан таны оюун санааг шинэчилж бодол, итгэлийг тань шинэ мөн чанарын үнэнтэй нийцүүлэхийг хүсдэг.

--

--



Жишээлбэл, та үргэлж өөртөө итгэлгүй, сэтгэл хангалуун биш мэдрэмжийг тээдэг гэж төсөөлцгөөе. Мөн би бол найдваргүй хүн гэсэн худал хуурмаг итгэл үнэмшилтэй гэж бодъё. Энэ мэдрэмж маань лавширсаар таны худал хуурмаг итгэл үнэмшлийг өөгшүүлж “би итгэлгүй байдлыг гмэдэрдэг” гэдгээс “би бол найдваргүй хүн” гэсэн цэгт хүрдэг. Тэгээд энэ найдваргүй байдлыг өдөөх нөхцөл байдал тохиох бүрт таны найдваргүй гэсэн худал хуурмаг итгэл үнэмшил батжидаг. Өөрөөр хэлбэл, “Би мэдэрдэг” гэдэг нь “би бол” болж хувирдаг.




Өөрчлөлтийн үйл явц дунд тэдгээр гэмтэлтэй сэтгэл хөдлөл таны оюун санааг эзэмдэхээ байх бөгөөд та өөрийн мэдрэмжээс илүүтэйгээр үнэн мөн чанарыг хардаг болох юм. Өөрөөр хэлбэл, тэдгээр гэмтэлтэй сэтгэл хөдлөл бий болоход “би цаашид энэ сэтгэл хөдлөлөөр өөрийгөө захируулахгүй. Би өөрийн үнэн мөн чанарт итгэхийг сонгож байна ” гэх болно.

Жишээлбэл, та өөрийгөө болгочидог нэгэн гэж боддог байлаа. Та өөрийгөө болгох тэр мөч бүрт би өөрийгөө болгочихдог гэсэн худал хуурмаг итгэлээ өөгшүүлж байдаг. Харин та оюун бодлоо Христээс л ирдэг хангалуун байдлаар (2 Коринт 9:8) шинэчлүүлэх үед тэдгээр өөрийгөө болгодог мэдрэмж таныг эзэмдэхээ больж эхэлнэ гэсэн үг. (Санамж: Өөрчлөлтийн алхам хийх эхэн үеүүдэд тэрхүү мэдрэмжүүдэд их автах болно) Гэвч, цаг хугацаа өнгөрөхийн хирээр Та Христээс ирдэг хангалуун байдалдаа итгэж эхлэх бөгөөд өөрийгөө болгодог мэдрэмж Христээс ирдэг хангалуун байдалд давамгайлуулах болно. Мэдээж энэ өөрчлөлтийн явц өөрийгөө болгодог мэдрэмжийг бүрэн арилгахгүй ч тэр нь таныг “би мэдэрдэг” гэдгээс “би бол” гэдэг байр суурь руу цаашид аваачихгүй.

Таны оюун бодол
Та итгэдэг зүйлс

Таны сэтгэл хөдлөл
Таны мэдрэмжүүд





***Бид оюун бодлоо үнэнээр ШИНЭЧИЛЖ, гэмтсэн сэтгэл хөдлөлөө ЭДГЭЭЛГЭХЭЭР
Бурханыг эрэн хайсны дараа худал хуурмаг итгэл үнэмшлээс илүү өөрийн үнэн мөн
чанарынхаа ҮНЭНЭЭР амьдрахыг сонгож эхлэх болно.***



Яг энэ үйл явдал бодит амьдрал дээр харагдах байдал нь гэвэл би чадамжгүй бодол, сэтгэл хөдлөлүүдэд “үгүй” гэж хэлж эхэлсэн. Өөрөөр хэлбэл, би цаашид тэдгээр бодлыг толгойдoo байлгахаа больж эхэлсэн гэсэн үг. Цаг хугацаа өнгөрч, үнэнд итгэдэг болсноор Эзэн миний махан биеийн зан чанаруудаас чөлөөлж эхэлсэн. Эрх чөлөөтэй болсон нь өөрийн зөвт байдал, өө хайгч, шүүмжлэгч гэх мэт махан биеийн зан чанаруудыг гаргах нь багассаар байсан. Бурхан энэхүү махан биеийн зан чанаруудыг хайр, хүлээн зөвшөөрөл, даруусал гэх мэт бурханлаг зан чанараар сольж өгч эхэлсэн. Энэ бол махан биеийн зан чанараас цаг хугацааны явцад чөлөөлөгдөх ер бусын үйл явц байсан юм.





Бурхантай хамт алхах нь: Нэгдүгээр хичээл дээр бичэн худал хуурмаг итгэл үнэмшлүүдээс сонгоод Бурханаар оюун бодлоо үнэн рүү шинэчлүүлэх итгэлийн алхамыг хийж эхлээрэй. Итгэлийн алхамын жишээг харуулбал:



Жишээ #1: “Эзэн, би чадамжгүй гэдэг худал хуурмагт итгэж байна. 2 Коринт 3:5 ишлэлд таны үг хэлэхдээ Таны дотор би бүрэн чадамжтай гэдэг. Энэ үнэнээр оюун бодлоо шинэчлүүлэхээр Танд итгэмжлэн даатгаж байна”

Гол Санаа: Та итгэлийн алхам хийхдээ Бурханы үнэнийг үгээр тунхаглаж, хэрэглэх нь чухал юм.

Жишээ#2: “Би өөрийн IQ болон чадамжийнхаа улмаас өөртөө итгэлтэй гэсэн худал хуурмагт итгэдэг. Гэхдээ надад итгэлтэй байдал нь зөвхөн Таны дотор байдаг гэдэг үнэнээр ятгаач. Би үнэн мөн чанар дотроо өөрийнхөөрөө алхахыг хүсэхгүй байна”



Итгэлийн алхам: "Миний хань _____ гэж итгэдэг. Харин түүний худал хуурмаг итгэл үнэмшлийг Христ доторх үнэнээр _____ хэмээн шинэчилж өгөөч."

Түлхүүр үнэн: Ханьдаа гологдоно гэдэг бол гэрлэлтийн хамгийн хэцүү зөрчлүүдийн нэг. Бид ханьдаа гологдмол мэдрэмж өгөх зүйлсийг хэлчих гээд байдаг. Гэхдээ сайхан мэдээ нь бид ханийнхаа хэлсэн голох үгийг хүлээж авах шаардлагагүй бөгөөд та Христ дотор бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн юм. Тэрхүү үнэнээр амьдрах нь таны гэрлэлтийг хэрхэн өөрчлөх вэ? Доор энэ талбар дахь итгэлийн алхам хэрхэн харагдах талаарх жишээг харуулсан байна.



1. Таны бодол худал хуурмаг итгэл үнэмшлийн оронд үнэнтэй нийцэх болно.
2. Таны оюун бодол шинэчлэгдсэнээр таны сэтгэл хөдлөл бодолтой тань нийцэх болно.
3. Мэдээж та худал хуурмаг итгэл үнэмшлээс гарах мэдрэмжийг мэдрэх боловч түүндээ байнга хариу үйлдэл үзүүлээд байхаа болино.
4. Таны сэтгэл хөдлөл үнэнтэй давхцаж, оюун бодол шинэчлэгдэхэд та үнэн дээр тулгуурлан шийдвэр гаргаж байгаагаа харах болно.
5. Та өөрчлөгдсөнөөр Бурхан таны махан биеийн зан чанарыг бурханлаг зан чанараар өөрчлөх болно.


Та шинэ мөн чанарынхаа үнэн дотор амьдрах нь ямар харагдах вэ?

Таныг худал хуурмаг итгэл үнэмшлээс чөлөөлөгдөхийн тулд Түүнтэй итгэлээр хамтраасай гэж Бурхан хүсдэг тухай энэ хичээлд онцгойлон авч үзлээ. Тэр таныг оюун бодлоо шинэчлүүлж, амьдралаа өөрчлүүлэхийн тулд итгэлийн алхам хийгээч хэмээн урьж байна. Тэгсэнээр бид худал хуурмагаас гарах махан биеийн зан чанараар цаашид амьдрах хэрэггүй болно.

Шинэ мөн чанартайгаа нийцүүлж оюун бодлоо шинэчлэхитгэлийн алхмыг хэрхэн хийх талаар өмнөх хичээлд үзсэн. Нэгдүгээр бүлгээс бид итгэлийн алхам хийх үед Бурхан биднийг өөрчлөн шинэчлэх үйл явцыг эсэргүүцэгч хүчтэй нүүр тулдаг гэж сурсан. Тиймээс бид энэ эсэргүүцлийг ялан дийлэхийн тулд Бурхантай хэрхэнхолбоотой байхыг суралцах болно.



Бидний итгэлийн алхаанд саад учруулж байдаг өөр хоёр хүчин зүйл байдаг. Эхнийх нь нөхцөл байдал, удаахь нь бусад хүмүүс. Дараагийн диаграмд бид махан биеийн дотоод эсэргүүцэл, мөн гэм нүглийн хүч чадал, Сатан болон ёрын хүчин, нөхцөл байдал, хүмүүсээс ирэх гадны эсэргүүцлүүдтэй тулдгийг харуулж байна.



Биднийг махан бие, гэм нүглийн хүч чадал, нөхцөл байдал, хүмүүсийн нөлөөнөөс шинэчлэн өөрчлөх Бурханы ажилд үргэлж ЭСЭРГҮҮЦЭЛ байдаг юм.



Юун түрүүнд, бид өөрийн талаар буруу итгэл үнэмшил болон зан авирт удирдуулан амьдарч ирсэн тул өөрчлөгдөх сэдэл бүр аль хэдийн дотор маань бэхжин тогтсон махан биеийн зан авираас болж эсэргүүцэлтэй тулгарах болно. Тиймээс бусад хүмүүс болон нөхцөл байдал миний өөрийнхөө тухай буруу итгэл үнэмшлийг бататгах үед тухайн худал итгэл үнэмшлээс үүдэлтэй махан биеийн зан чанар шууд идэвхжиж эхэлдэг. Учир нь энэ нь бидний дадсан тав тухтай байдал юм. Эдгээр махан биеийн зан авираас үүдэлтэй зүйлийг би “махан биеийн эрх” гэж нэрлэдэг.

Энэ зарчмыг ойлгуулах нэгэн жишээг дурдъя. Та нэгэн компанийн захирал бөгөөд өөртөө итгэх итгэлийн талаарх худал хуурмаг итгэл үнэмшилтэй. Энэ худал хуурмаг итгэл үнэмшлээс бусдад шүүмжлэлтэй ханддаг, шаардлага өндөртэй байх гэх мэт махан биеийн зан авир гардаг. Тэгээд ажилчдын нэг нь таны шаардлагад хүрэхгүй байвал таны махан бие

Худал хуурмаг итгэл үнэмшил болон зан авир таны дотор бат бэхжсэн учир махан биеийн зан авираас үүдэлтэй би эрхтэй гэж бодох нь дадал болсон байдаг. Өөрөөр хэлбэл, та бусдад үргэлж шүүмжлэлтэй хандаж ирсэн учир хэн нэгэн таны шаардлагад нийцэхгүй байхад та шууд л өөрийн эрхийн тухай бодож эхэлдэг гэсэн үг.



- Бурхан биднийг өөрийн махан биеийн эрхээ ҮХЭЛД тушаагаасай гэж хүсдэг - 2 Коринт 4:11
- Махан биеийн өөрт болон бусдад учруулж буй үхлийг ИЛГАРГАН харуулж Бурхан ажилладаг - Ром 8:6
- Махан биеийн эрхээ үхүүлсэний дараа Бурханаас үнэнээр шинэчлэгдсэн оюун санааг ЭРЭН ХАЙХ ёстой – Матай 7:7
- Бурхан миний оюун санааг шинэчлэхдээ намайг махан биеийн эрхээ ЦААШИД ашиглах хүсэл төрүүлэхгүй газар аваачин чөлөөлдөг. Иохан 8:32

Дээрх дөрвөн зарчмыг жишээн дээр хэрэгжүүлж үзье. Эхлээд Ариун Сүнс намайг шаардлага өндөртэй, шүүмжлэгч нэгэн байх махан биеийн эрхээ үхэлд тушаагаасай гэж хүсч байгаа. Энэ шүүмжлэгч хандлага өөрт маань болон бусдад учруулж буй үхэл буюу сэтгэлийн зовлонг надад илчлэн ойлгуулах ажлыг Ариун Сүнс хийнэ. Энэ зовлонг харсаны дараа би дараах байдлаар итгэлийн алхам хийж эхлэх болно.

Ресторанд байх амттаны тавиур мэт гэм нүглийн хүч чадал ньмахан биеийн хүсэл, зан чанарыг өдөөдөг гэдгийг санаарай. Итгэлийн алхааны эхэн үед гэм нүглийн хүч чадал таны худал хуурмаг итгэл үнэмшлийг бүрэн атгасан байдаг. Та өөрийн жинхэнэ мөн чанарын дагуу оюун санааг тань шинэчлэхийг Бурханд зөвшөөрөх үед, тодорхой талбарууд дээр гэм нүглийн хүч чадлын ноёрхол, нөлөө багасч байгааг мэдрэх болно.

Жишээ:Би гологдсон нэгэн гэж та үргэлж мэдэрдэг гэж бодъё. Энэ мэдрэмжийг хэн нэгэн танд төрүүлэх үед уур уцаар, өөрийгөө зөвтгөн хамгаалах, эсвэл бусдыг үл тоох махан биеийн зан авирыг гэм нүглийн хүч чадал улам өрддөг. Та хүлээн зөвшөөрөгдсөн, хайрлагдсан нэгэн гэсэн үнэнээр оюун санааг тань шинэчилж өгөхийг Бурханаас хайж эхэллээ гэж бодъё. Энэ өөрчлөлтийн эхний үе шатанд таныг ноёрхож буй гэм нүглийн хүч чадлын улмаас та эдгээр зан авираас нэг болон хэд хэдийг нь

гаргаж, өлгөн авч хариу үйлдэл үзүүлж байх болно. Харин Бурхан таны оюун санааг шинэчлэхэд гэм нүглийн хүч чадал таны махан биеийн зан чанарыг идэвхжүүлсэн ч та түүнд автахгүй байгаагаа мэдрэх болно. Учир нь юунд байгаа юм бол?

Үнэнтэй учрах нь = ХҮЧ ЧАДАЛ



Ямар утгатай юм бол? Жинхэнэ мөн чанарынхаа тухай үнэний мэдлэг дотор өсөх тусам, та Бурханы хүч чадлыг мэдэрч эхлэх болно. Таны доторх Бурханы хүч чадал аажмаар гэм нүглийн хүч чадлаас илүүгээр ажиллаж эхлэх юм.

Ингэж бодоод үздээ. Гэм нүглийн хүч чадлыг хүндийн өргөлтөөр хичээллэдэг залуугаар төсөөлөөд өөрийн бодлын хүчийг бяцхан хүүгээр төсөөлөөд тэдний хоорондынгардан тулааныг боддоо. Хүч үзэхэд гэм нүглийн хүч чадал нь эсэргүүцэх гэсэн бодлын хүчийг хялбархан ялна. Гэвч та итгэлийн алхаа хийж эхлэх үед Бурхан таны бодол, сүнсний хүчийг гэм нүгэлд үгүй гэж няцааж чадах газар аваачих бөгөөд та ямар ч гэм нүглийн хүч чадал, махан биеийн зан авирт хүлэгдэхгүй болох юм.

3. Таны итгэлийн алхаанд учруулах Сатаны/ёрын хүчний эсэргүүцэл

Сатан болон түүний ёрын хүчний огт хүсдэггүй зүйл бол таныг эрх чөлөөтэй нэгэн болгох. Сатан болон түүний арми таны жинхэнэ мөн чанар юу болохыг сайн мэддэг. Хэрвээ таныг үнэн дотор алхаад эхэлвэл өөрчлөлт болон шинэчлэлт явагдан эрх чөлөөг олохболно гэдгийг тэд сайн мэддэг. Тиймээс тэдний гол төлөвлөгөө бол өөрийн тань тухай худал хуурмаг итгэл үнэмшлийн хүлээсэнд байлгах юм.

***Энэ зорилгодоо хүрэхийн тулд таныг өөрийн жинхэнэ мөн чанараа олж МЭДЭХЭД саад
УЧРУУЛДАГ юм.***

Сатан болон түүний арми таныг үнэнийг мэдэхэд саад учруулж чадахгүй бол оюун санаагаа үнэн дотор шинэчлүүлэхээр Бурханыг эрэн хайх итгэлийн алхааг тань сульдуулахаар хийж болох бүх зүйлийг хийдэг. Тэдголчлон таны бодлоор дамжуулж ажилладаг.

Таны дотор хийж буй Бурханы өөрчлөлтийн үйл явцад Сатан таны оюун бодлоор дамжуулан хэрхэн эсэргүүцэл үүсгэдгийг дараах жишээгээр харья.

1. Махан биеийн зан чанар гаргасны дараа **буруутган ялласан** бодлыг төрүүлэх



- А. Чи хэзээ ч чөлөөлөгдөж чадахгүй
 В. Энэ хийгээд байгаа итгэлийн алхаа чинь ямар ч үр дүн авчрахгүй
 С. Чи ингэсхийж байгаад л болино

доо

3. Оюун санааг шинэчлэх **Бурханы хүсэл болон чадалд** нь эргэлзэх бодлыг бий болгох

- А. Хэрвээ Бурхан оюун санааг чинь шинэчилж чадах юм бол яагаад одоо болтол юу ч хийхгүй байгаа юм бэ?
 В. Бурханы хэрээс ч хэтэрсэн их өөрчлөлт чамд

Өөрийн нэг жишээгээр тайлбарлавал: Жинхэнэ мөн чанарын тухай бусдад зааж эхлэх үедээ би өөрийгөө Христ дотор дутах юмгүй гэдэгт бүрэн дүүрэн итгэхэд суралцаж байсан юм. Гэвч би хангалттай сайн бишээ гэсэн бодол миний дотор хүчтэй хэвээр л байлаа. Хамгийн эхний сургалтаа би ерөөсөө мартдаггүй юм. Сургалтаа зааж дуусангуут би “чиний ярьсан зүйлийг хэн ч ойлгоогүй, маш муу тайлбарлалаа, чи хэзээ ч сайн туршлагатай багш нар шиг зааж чадахгүй” гэсэн дуу хойлойг сонссон юм. Эргээд бодоход Сатан болон муу сүнснүүд намайг энэ үнэнийг заахыг зогсоохыг бүхий л аргаар үзэж байжээ гэж хардаг. Харин Христ дотор би юугаар ч дутахгүй гэсэн үнэнээр Бурхан миний оюун ухааныг шинэчилсэн бөгөөд эдгээр бодлууд хаанаас эхтэй байна гэдгийг ялгах чадварт би сургагдсан юм.

Бурхантай хамт алхах нь: Өөрийн мөн чанарын тухай худал хуурмаг, буруутгасан, эргэлзээтэй бодол төрж эхэлмэгц бүх бодлынхоо эхлэлийг Бурхан дээр аваачдаг “ариун” зуршлыг хэвшүүлээрэй.

Нөхцөл байдлууд нь бидний худал итгэл үнэмшлийг лавшруулан, сэтгэл хөдлөлийг тавгүйтүүлж, махан биеийн зан авираар Бурханы шинэчлэлийн ажилд эсэргүүцэл учруулдаг. Нэгэн жишээгээр тайлбарлья.

Та өөрийгөө их айдастай хүн гэж боддог байлаа. Нэг өдөр ажилдаа очтол компани нь олон хүнийг хална гэсэн яриа гарсан байв. Үүнийг сонсох мөчид айдас таныг хучин авна. Та тэр айдсыг шууд л тосч авдаг ба энэ таны аль хэдийн тогтсон худал итгэл үнэмшлийг бэхжүүлэн улмаар таны бодол мэдрэмжийг дарамталж эхэлнэ.

Бурхантай хамт алхах нь: Тодорхой нэгэн худал хуурмаг итгэлээс салан эрх чөлөөг мэдрэхэд ямар нөхцөл байдал танд саад учруулж байна вэ? Одоо харин тухайн нөхцөл байдал үүсэхэд Бурханыг эрэн

хайх хэрэгцээг илчилж мөн тэр талбарт шинэчлэлт явагдахад Бурханаас бүрэн хамаарлыг гуйн залбираарай.



Бусад хүмүүс ялангуяа ойр дотныхон эсвэл гэр бүлийн хүмүүс зарим тохиолдолд маш том эсэргүүцлийг үүсгэдэг. Эдгээр харилцаанаас ирэх сөрөг юм уу, буруутгасан хандлагууд нь өөрийн тань талаар буруу итгэл үнэмшлийг бататгаж өгдөг. Бидний дотор явагдаж буй Бурханы ажилд ойр дотны хүмүүсээс үзүүлэх өөр нэг эсэргүүцэл бол үл уучлах сэтгэл юм. Хэрвээ та хэн нэгэнд гомдсон, шархалсан бол энэ нь таны худал итгэлийг зөвтгөн таны махан бие “Би уучлахгүй байх эрхтэй хүн” гэж хэлж эхэлдэг.

Дүгнэж хэлэхэд, гадаад хүчин зүйлсээс үүдэлтэй ил болон далд эсэргүүцэл байх болно гэдгийг ойлгох нь чухал юм. “Зааглах шугам” гэж нэрлэсэн зүйлийнхээ тухай тайлбарлах нь Бурханы шинэчлэлийн үйл явцын талаар илүү бодитойгоор ойлгоход туслах болно.

Еврей 4:12 ишлэл дээр сэтгэл болон сүнс нь тус тусдаа юм гэдгийг сануулсан байна. “**Зааглах шугам**” гэсэн үлдсэн хичээлийн турш ашиглагдах дүрслэлийг харцгаая. Зааглах шугамын дээд хэсэг Сүнснээс эхтэй амьдрал бөгөөд таны өөрийн сүнс Бурханы Сүнстэй нэгдсэн байдал юм. Харин доод хэсэгт нь өөрийн сүнснээс эхтэй амьдралыг харууллаа.

Зааглах шугам _____


Үзэгдэх болон үл үзэгдэх зүйлсийн ялгааны талаар нэмэлт 2 тайлбар хийе. 2 *Коринт 5:7* дээр гарч буй итгэлээр алхах газар нь Бурхантай нэгдмэл байх үл үзэгдэх газар юм. Бидний сэтгэл дэх үзэгдэх юмс нь "харагддаг зүйлс" буюу "туршлага"өгдөг зүйлс юм. Сэтгэлдотроо бид амьдралын мөч бүрийг туулж, мэдэрдэг.

Энэ 2 амьдралын ялгааг ойлгох нь чухал бөгөөд итгэл нь мэдрэмж болон туршлагыг заавалагуулах ёстой биш юм. (Дараагийн бүлэгт энэ талаар илүү дэлгэрэнгүй үзэх болно) Итгэл нь үргэлж нэг объекттэй байх хэрэгтэй болдог бөгөөд Христитгэлийн объект нь Бурхан юм. "Зааглах шугам"-ын дүрслэл дээрээ энэ хоёр зарчмыг нэмж харья.

Зааглах шугам



Асуулт: Яагаад Бурхан үл үзэгдэх юмсад итгэх итгэлийг үзэгдэх баригдах зүйлсээс илүү хүчтэй болгохыг хүсдэг вэ?



Хүний сүнсэн дэх үнэн мөн чанар "зааглах шугам"-ын дээр, таны сэтгэл зүрхний мөн чанар "зааглах шугам"-ын доор дүрслэгджээ.

Худал хуурмаг итгэл үнэмшлээр амьдрахыг сонгох хүсэл МАХАН БИЕИЙН ЗАН ЧАНАР


Өмнөх дүрслэлийг ойлгосны дараа Бурхан таныг хаана амьдраасай гэж хүсдэг гэж бодож байна? Жинхэнэ мөн чанараараа буюу "зааглах шугам"-ын дээр үү эсвэл зүрх сэтгэлийнхээ хүслээр буюу "зааглах шугам"-аас доор уу? Бурхан биднийг худал хуурмаг итгэл үнэмшлээр биш харин үнэнээр удирдуулан амьдрахыг хүсдэг нь тодорхой.

Бурханы хүсэл бол бид жинхэнэ мөн чанар дотроо “Зааглах шугам”-аас ДЭЭШ амьдрах юм.

Бид хэрхэн “Зааглах шугам”-аас дээр амьдарч чадах вэ?

Бид хэрхэн "зааглах шугам"-аас дээгүүр амьдарч, өөрсдийн санаа бодлыг дээгүүрх зүйлсийг эрэн хайхад тавих вэ? Бидэнд амлагдсан жинхэнэ мөн чанараар хэрхэн өдөр бүр амьдарч чадах вэ? Хариулт бол **ИТГЭЛ** юм. Итгэл нь зөвхөн Бурхантай нэгдмэл байх газар төдийгүй сэтгэлээс эхтэй амьдралыг Сүнс рүү шилжүүлж өгдөг юм. 1 Иохан 5:4-д бидний итгэл бол ялалт юм гэж хэлсэн.

Дараах диаграммаар итгэл нь хэрхэн биднийг өөрийн сэтгэлээс эхтэй амьдарлаас Сүнсээр удирдуулсан амьдрал руу удирдан дагуулдаг болохыг харж болно.



ИТГЭЛ нь биднийг өөрөөсөө эхтэй амьдрал буюу “зааглах шугам”-ын доороос шилжиж үнэн мөн чанараараа амьдрах “зааглах шугам”-ын дээд тал руу аваачдаг.

Энэ үнэнийг өмнөх зурагтай холбож харья. Бурханы ажилд бидний хийх зүйлс бол жинхэнэ мөн чанараараа амьдарч эхлэх итгэлийн алхам хийж эхлэх юм.

Золиос гаргадаг


Хангалттай

Амиа боддоггүй

Баяр хөөртэй

Амар тайван

Сайн



**Худал хуурмаг итгэл үнэмшлээр амьдрахыг сонгох хүсэл
МАХАН БИЕЙН ЗАН ЧАНАР**

“Зааглах шугам” ба Бурхан зүрх сэтгэлийг шинэчлэх нь

Өмнө нь сурсанчлан, Бурхан бидний зүрх сэтгэлийг шинэчлэхийг хүсдэг:

Оюун ухаан – Жинхэнэ мөн чанарын үнэнд итгэх байдалд шинэчлэгдэх

Христтэй адил зан чанар – Үр дүнд нь төлөвших юм:

Золиос гаргадаг

Хангалттай

Амиа боддоггүй



Зүрх сэтгэлдээ Христтэй адил хандлагыг тээхүй:

Таны зүрх сэтгэлд хандсан Бурханы туйлын зорилго юу вэ?

Таны зүрх сэтгэлд хандсан Бурханы туйлын зорилго Филиппой 2:5, 2 Коринт 3:18, болон Галат 4:19 ишлэлүүд дээр гардаг.

Бурханы туйлын зорилго бол хүний сүнсэн доторхүнэн МӨН ЧАНАР Христтэй адил хандлагаар сэтгэлд тань илэрхийлэгдэхэд оршдог юм.

Таны үнэн мөн чанарын хувьд, өөрчлөлт гэдэг нь таны мөн чанар Христтэй адил хандлагаар таны сэтгэлд илэрхийлэгдэхүйл явц юм. Христийг дуурайсан хандлага гэж юу вэ?


таны сүнсний үнэн мөн чанарын шинжүүд сэтгэл дотор чинь бодит болон төлөвшинө гэсэн үг юм.

Галат 5:22,23 дээр гардаг Сүнсний үр жимсүүд нь таны үнэн мөн чанарууд бөгөөд улмаар Христтэй адил хандлага болон илэрхийлэгдэх юм.

“Тиймээс Бурханаар сонгогдсон, ариун хийгээд хайрлагдсан хүмүүсийнхээ хувьд та нар өрөвч зүрх, энэрэл, даруу байдал, дөлгөөн зан, тэвчээрийг өмс. Ингэхдээ нэг нэгнээ хүлцэж, бие биеэ

уучилж, хэрэв хэн нэгэнд чинь нөгөөгийнхөө эсрэг гомдол байвал та нарыг Эзэн уучилсны адил та нар бас уучил. Энэ бүгдийн дээр хайрыг өмс. Хайр бол эв нэгдлийн төгс холбоос юм.”

Таны үнэн мөн чанарын зарим шинжүүдийг доор дурдлаа. Бурханы хүсэл бол таны зүрх сэтгэлийг өөрчлөн шинэчилж, Христтэй адил хандлагатай болгох юм:



Таны сүнсэн дотор буй үнэн мөн чанар сэтгэл дотроос тань Христийг дурайсан хандлага болон илэрч гарахыг үзүүлсэн доорх диаграммыг харна уу.

Сэтгэл дотор бүрдсэн Христтэй адил зан чанарууд



Аюултай

Итгэлийн алхам


*Аюулгүй
Хангалттай
Айдасгүй*

Итгэлийн алхам

*Аюулгүй
Хангалттай
Айдасгүй*

Та хэдийгээр буцаж худал хуурмагт итгэдэг амьдрал руугаа эргэхийг хүсэхгүй байгаа ч, итгэлийн алхааны эхэн үедээ махан биеийн зан чанарыг гаргадаг үе рүүгээ эргэх болно. Учир нь энэ байдал нь таны удаан дадал болсонзүйл юм. Мөн итгэлийн алхааны эхэн үед та миний хэлдгээр сул итгэлтэй, Есүсийн хэлдэгээр бага итгэлтэй байх юм. Сул итгэл гэдэг нь Бурханы үнэн мөн чанар, хүч чадалд итгэхгүй, эргэлзээ ихтэй байгаагийн илрэл юм. Эхэн үед таны махан бие, худал итгэл таныг ноёлж байх ч итгэлийн алхам хийсээр байвал таны мөн чанарын тухай үнэн махан бие, худал хуурмаг итгэл үнэмшлийг тань давсан хүчтэй болох юм.

“Зааглах шугаман” дүрслэлээр илэрхийлсэн үнэнг сайн харна уу. Зурагны зүүн талд буюу итгэлийн алхааны эхэн үед “зааглах шугам”-аасдоор буй махан биеийн зан чанар, худал хуурмаг итгэл үнэмшил дотроо их цаг өнгөрөөнө гэсэн үг юм. Гэвч та итгэлийн алхаагаа үргэлжлүүлэн хийснээр “зааглах шугам”-аас дээр буй үнэн мөн чанараараа амьдарч байгааг харах болно.



Та махан биеэр удирдуулсан амьдрал руугаа буцах үеүд олон гарах ч, тэр болгонд гэмшснээр эх сурвалж болсон Бурхан руу эргэх болно гэдгийг сайн САНААРАЙ.

Таны худал хуурмаг итгэл үнэмшил танд нэвт шингэсэн учир, та итгэлийн алхааны эхэн үедээ зориудын зориулалттай байх нь чухал. Чөлөөлүүлж, оюун санаагаа шинэчлүүлэхээр та Бурханыг хайсаар л байгаарай. Эсэргүүцэл эхэн үедээ хүчтэй байх учир сөрж зогсох хүчээр сэлбүүлж байх учиртай.

#2Бурханы ажиллах цагтаны цагийн хуваариасөөр байж болно



Та өөрчлөн шинэчлэлтийг хайж эхэлмэгцээ Бурхан таны худал хуурмаг итгэл үнэмшлийг тэр дор нь өөрчилж, оюун бодлыг аль болох л хурдан өөрчлөөсэй хэмээн хүсэх болно. Харин удалгүй та Бурханы ажиллах цаг хугацаа таны цагийн хуваариасөөр болохыг ухаарах болно. Миний хувьд Бурхан миний хүссэн хугацаанаас удаан ажилладаг юм шиг санагддаг. Гэвч Бурхан бол бүгдийг мэддэг Өөрийн хамгийн төгс цаг хугацаагаар ажилладаг гэдгийг санах хэрэгтэй.

Бурханы цаг хугацааг хүлээх өөр нэг зорилго бол Бурхан танд тэвчээрийг сургаж байгаа юм. Таныг хүлээлгэснээр Бурханы зааж буй хамгийн чухал зүйл нь итгэл юм. Бурханыг хүлээх боломж бүрдэхгүй бол өөрөөр бид итгэлийг яаж сурах билээ? Итгэлийг өөр нэгэн ингэж тодоройлжээ: “Та амьдралдаа ямар ч өөрчлөлт харахгүйгээр хир удаан итгэсээр байж чадах вэ?”

Бурхантай хамт алхах нь:Өөрчлөн шинэчлэлт таны хүссэний дагуухурдан болохгүй байна гээд Бурханы товлосон хугацаанд сэтгэл хангалуун биш байвал, Бурханыг танытэсвэр тэвчээр болооч хэмээн эрэн хайж эхлээрэй.

Энэ судлалын явцад Бурхан танд илчлэн харуулсны дагуу Христ доторх өөрийн үнэн мөн чанараар оюун санаагаа өөрчлөн шинэчлүүлэхийн тулд Бурхантай илүү ойр харилцаатай амьдрах эхлэлээ тавьсан байж болох юм. Та энэхүү оюун санааны аялал тань **ер бусын** үйл явцтай байх болно гэдгийг ойлгоорой.

Бурхан ер бусын аргаар таны бодох, мэдрэх, сонгох, аашлахыг өөрчлөх болно. Ер бусын гэдэг нь бид юу ч хийж чадахгүй гэсэн үг юм. Бурхан биднийг хэрхэнөөрчлөхийг мэдэхийг хүсдэг ньбидэнд асуудал болдог. Бидний алхаа бол итгэлийн алхам юм. Бурхан биднийг Өөрт нь болон бидний амьдралыг **ер бусын** аргаар шинэчлэх үйл явцад нь бүрэн итгэхийг хүсдэг юм.

#4Өөрчлөн шинэчилж буй Бурханы хүч чадлыг мэдрэхгүй байж болох юм

Ихэнх үед, итгэл гэдэг бол мэдрэмж болон туршилагаас давсан “НАЙДЛАГА” юм

Бурхантай хамт алхах нь: Өнөөдөр биеэрээ мэдрэхгүй байж болох ч Бурхан таны дотор ажиллаж буй гэдэгт баталгаа өгөхийг Бурханаас гуйгаарай. Бурханаас итгэлийн талбарыг харагддаг бодит талбар болгож өгөхийг гуйгаарай.

Зарим талбар дээрх худал хуурмаг итгэл үнэмшлийн хүч чадал их учир түүнээс чөлөөлөгдөх явцад олон удаа алдаж эндэж, унаж босч болох юм. Ингэх ч учиртай юм. Дайсан юм уу, өөрийн оюун бодол тань танд буруутгал өгөхийг зөвшөөрөх хэрэггүй юм. Бурханы өмнө ирж гэмшээд дараагийн алхмаа хийгээд яваарай.

#6Өөрчлөн шинэчлэлт эхэлмэгц Танд Бурханднайдахитгэл өсөх болно

Би өөрийн санаа зовнил, сэтгэл ханамжгүй байдал, худал хуурмаг итгэл үнэмшлээсээ чөлөөлөгдөж эхэлсэн үеэ огт мартдаггүй юм. Миний Бурханд итгэх байдал улам өсч эхэлсэн. Би өнөөдөр бол Христийн амар тайван, бялхам дүүрнийг мэдэрч амьдардаг. Миний зан чанар Бурханы үнэний дагуу шинэчлэгдэж эхлэхэд уур уцаар, шүүмжлэгч хандлагын хүлээснээс ангижирч Бурханд итгэх итгэл маань өсч эхэлсэн. Та итгэлийн алхааг үргэлжлүүлэн хийсээр байвалөөрчлөн шинэчлэлтийг мэдэрч, Бурханд итгэх итгэл тань өссөн байгааг харах болно.

Би өөрчлөлт явагдсан эсэхийг яаж мэдэж чадах вэ?

- 4. Та одоогийн хүсэл зориг бодож, мэдэрч буй үнэн дээр суурилсан сонголт хийж эхлэнэ. Энэ нь таныг үнэний дагуу оюун бодлоо шинэчлүүлэхээр улам л Бурханыг эрэн хайж түүн рүү очдог болоход урамшуулах болно.**

Дээрх жишээнүүд Бурхан таны худал хуурмаг итгэл үнэмшлийг Өөрийн үнэнээр сольж байгаа баталгаанууд юм. Түүний ажлыг таньж мэдэх нэг түлхүүр нь сүнсний ухамсартай болж сонор соргог, анзааргатай болох юм. Таны амьдралд Бурхан хэрхэн Өөрийн ажлаа баталгаажуулж өгч байгааг үргэлж анзаарч сонор соргог байгаарай. Бурхан таныг зөвхөн танд тохирсон тэр л аргаар өөрчлөх болно гэдгийг санаарай. Тиймээс Бурхан ингэж ажилладаг гэсэн нэг тогтсон томъёо байхгүй юм шүү.

--

Мөн чанар

Үнэн мөн чанараасаа эхтэй амьдрах нь: Ханийнхаа махан биеийн зан чанарт түүртээд байлгүй (гэхдээ энэ нь зөвтгөж, өөгшүүл гэсэн үг биш шүү) Христ доторх шинэ бүтээл гэдгээр нь хараарай. Яг л тантай адил, түүний зан чанар мөн чанарыг нь илэрхийлэхгүй гэдгийг санаарай.

Асуулт: Ханиа махан биеийн зан чанараар нь хязгаарлаж харах бус түүнийг Христ дотор шинэ бүтээл гэж харвал та хоёрын харилцаа хэрхэн өөрчлөгдөх бол?

Нөхцөл болзолгүй хайр

Үнэн мөн чанараасаа эхтэй амьдрах нь: Үнэн бол та Христ дотор болзолгүй хайраар хайрлагдсан ба та ч хэн нэгнийг болзолгүй хайраар хайрлаж чадах нэгэн юм. Тэгэхээр та болзолгүй хайраар хайрлагдах хэрэгцээгээ ханиасаа олох гэж хичээх хэрэггүй юм. Нэгэнт энэ хэрэгцээ тань Христ дотор хангагдсан учир, өөрөөрөө дамжуулан ханиа болзолгүй хайраар хайрлаж чадахыг Христээс гуйгаарай.

Асуулт: Христийн болзолгүй хайраар та ханиа хайрлавал гэрлэлт тань хэрхэн өөрчлөгдөх бол?

Гэрлэлтийн хичээл орох бүртээ би, гэрлэлтэнд үл тоомсорлол хамгийн том асуудал байдаг юм гэдгийг ойлгосон. Бид маш их хүлээлт, хэрэгцээтэйгээр гэрлэдэг. Эдгээр хэрэгцээ, хүлээлт маань хангагдахгүй байвал бид ханиа голж үл тоомсорлож эхэлдэг. Ийм гологдлыг мэдэрсэн хүн хариуд нь үл тоомсорлож эхэлдэг. Ингэж л эхнэр нөхрийн дундах үл тоомсорлолын тойрог эхэлдэг. Энэ хандлагыг засахгүй л бол гэрлэлт гунддаг.

Асуулт: Таныг гомдоосон ч гэмшээд уучлалын эхлэлийг тавибал таны гэрлэлт хэрхэн өөрчлөгдөх бол?

Аз жаргалтай гэрлэлтийн гол түлхүүр нь амиа бодож өөрийнхийг эрдэг биш золиосыг гаргадаг хандлага юм. Асуудал нь махан биеийн хүн бол маш амиа хичээсэн, золиосыг гаргадаггүй юм.

Үнэн мөн чанараасаа эхтэй амьдрах нь: Хэрвээ та өөрийнүнэн мөн чанараас эхтэй амьдарвал, та дотроосоо амиа бодоогүй (Филипой 2:4) золиосыг гаргадаг (Иохан 15:13) болно.

Асуулт: Та гэрлэлтийнхээ ямар талбарууд дээр амиа бодсон мөн зөвхөн өөрийнхийг эрдэгбэ? Та амиа бодсон биш мөн золиосыг гаргадаг хандлагатай болвол гэрлэлттаны хэрхэн өөрчлөгдөх бол?

Үнэн мөн чанараасаа эхтэй амьдрах нь: Христ доторх найдвартай байдал гэрлэлтэнд маш чухал юм. Яагаад гэвэл хүмүүс бид итгэлцэлд сэв суулгах зүйлс хийдэг. Ийм зүйлс тохиолдоход бид Христ доторхүнэн мөн чанараас л байнгын найдвартай байдал ирдэг гэдгийг санаарай. Хүний хамгаалал нурахад бид зөвхөн Христ доторх найдвартай байдалдаа найдах хэрэгтэй.

- Ажилтай холбоотой сэтгэл хангалуун болон сэтгэл хангалуун бус байдлууд

Ажлын стресс:

Ажлын байр болон бусад газарт стресс гэдэг бол үргэлж биднийнэг хэсэг байх болно. Гол асуулт нь та стрессийг өөр дээрээ маш хүндээр тусгаж авч байна уу гэдэгт байгаа юм. Хариулт нь ҮГҮЙ.

Үнэн мөн чанараасаа эхтэй амьдрах нь: Христ дотор, Түүний бүх хүч чадал танд байгаа. Тиймээс ажлын стресст үгүй гэж хэлж чадах хүч чадал танд байгаа. Та ажлаасаа ирж буй стрессийг өөр дээрээ цаашид хүлээж авах шаардлагагүй юм.

Асуулт: Ажлын нөхцөл байдлаас илүү Христ доторх баяр хөөр таны ажилдаа сэтгэл хангалуун байх байдлыг тодорхойлдог болвол таны ажлаа харах байдал хэрхэн өөрчлөгдөх вэ?

Өмнө дурдсанчлан, бидний мөн чанараа олж авах гэж оролдог гол талбаруудын нэг бол ажлын талбар юм (ялангуяа эрчүүд). Учир нь бид юуг хийдгээрээ өөрийгөө тодорхойлох гээд байдаг. Аль нь чухам үнэн бэ?

Үнэн мөн чанараасаа эхтэй амьдрах нь:Хэрэв та Христ дотор бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн (Ром 15:7) гэдэгтээ итгэвэл та хамтран ажиллагсад, боссоосоо ирэх няцаалтыг өөртөө тусгаж авах шаарлагагүй болох юм.

Бид “ажлын аюулгүй байдал” гэдэг үгэнд их дуртай байдаг. Гэвч, аюулгүй байдал хормын дотор л үгүй болж болно гэдгийг мэднэ. Та маргааш өглөө гэхэд ажлаа алдсанаа мэдэх үед аюулгүй байдлыг хир ихээр мэдрэх вэ?

Тааламжгүй нөхцөл байдал биднийг доорхтой адил мэдрэмж тээхэд хүргэдэг. Үүнд:

Үнэн мөн чанараасаа эхтэй амьдрах нь: Шинэ бүтээлийн хувьд бидний бүрэн итгэл Христ дотор байдаг (Дуулал 71:5). Түүнд буй итгэлтэй байдал байгаа тул бид цаашид махан биеийн өөртөө итгэх итгэл дор алхах шаардлагагүй. Христ доторх бидний итгэлтэй байдлыг юу ч хулгайлж чадахгүй.

Үнэн мөн чанараасаа эхтэй амьдрах нь: Үнэн бол бид Христ дотор ялалттай (1 Коринт 15:57). Үнэн бол бид Христ дотор ялалттай учир цаашид ялагдмал мэдрэмжийг тээх хэрэггүй. Ялагдмал гэмийн асуудлуудын тухайд Христ дотор байдаг ялалт дотор итгэлээр алхахыг эсвэл бууж өгөхийг сонгох боломжтой. Бууж өгнө гэдэг нь байнгын ялагдмал мэдрэмжийг үргэлжлүүлнэ.


Хэн ч өөрийгөө сул дорой хэмээн мэдрэх дургүй (Ялангуяа эрчүүд). Бид зовлон бэрхшээлийг сөрж зогсож чадахуйц хүний дотоод тэнхээтэй байхыг эрмэлздэг. Гэвч, Бурхан хүний сул дорой байдлыг илрүүлэх нөхцөл байдлуудыг бидний амьдралд зөвшөөрөхүйц бидэнд хайртай.

Үнэн мөн чанараасаа эхтэй амьдрах нь: Бидний жинхэнэ хүч тэнхээ Христээс л ирэх боломжтой (Ефес 6:10). Бид Христийн хүч чадлаар амьдарвал тэр хүчийг хулгайлах юу ч олдохгүй. Тиймээс ч Паул “би сул дорой байх үедээ хамгийн хүчтэй байдаг” гэж хэлдэг. (2 Коринт 12:10)


3. Шинэ мөн чанар дотроо алхах нь хайрлагдахуйц биш нэгнийг ч нөхцөлгүй хайрлахад сургана

Өөрийнхөө талаар худал хуурмагт
итгэсээр байх = илүү эмгэг, махан
биеийн зан авир, өөрчлөлт байхгүй

Өөрийн үнэн мөн чанараар амьдрах =
Оюун санааны шинэчлэл, эрх чөлөө,
Христтэй адил зан авир



Цаашид би яах вэ?



Христээр өөрчлөгдсөн амьдрал хэмээх дагалдагч бэлтгэх 4 цуврал номын 2-р дэвтрийг та гүйцээлээ. Энэхүү цувралын 3-р дэвтэр нь "Өөрчлөгдсөн байдал" гэдэг гарчигтай. Хэрэв та дараагийн хичээлийг сонирхвол, бидний үйлчлэлийн цахим хуудас: www.christislifeministries.com руу айлчлан Store гэдэг хэсгээс аваарай. Тэнд Христээр өөрчлөгдсөн амьдрал хэмээх цуврал байгаа. Та хэвлэмэл номыг онлайнаар худалдан авах буюу өөрийн цахим шуудангаар захиалах боломжтой. Мөн цахим хуудсаар орж үнэгүй татаж аван өөрийн хүссэн тоогоор хувилж болно.

- Бурхан бидний хүсэлгүй байдлыг хүсэлтэй болгох уруу чиглүүлэх үйл явц

Утас: + 976 7711 1225